



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 1169

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсад сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд “Сүрьеэгүй сум” зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Алтансүх

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүн:

Ч.Басбайгаль

(Эрүүл мэндийн төвийн жор баригч)

Нарийн бичгийн дарга:

Г.Анхбаяр

(1 дүгээр багийн Их эмч)

2. Арга хэмжээнд зарцуулагдах төсвийн дагуу 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг Нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д даалгасугай.

3. Арга хэмжээний төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг чанартай удирдан зохион байгуулж, тайлагнан ажиллахыг ажлын хэсгийн дарга (Б.Алтансүх)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *П.ГАНЧИМЭГ*



48123 270